

“Хамгаалалтын зурвас”-ын дэглэм сахиулах

2023.01.10

Компанийн хэмжээнд өндөр хүчдлийн шугам дэд станцын хамгаалалтын зурвасыг сахиулах чиглэлээр 2022 онд “ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС”-ЫН АЯНЫГ зохион байгуулж “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 14-нөөс 05 дугаар сарын 16-ны хооронд Улаанбаатар, Зүүн-өмнөд бүс, Говийн бүс, Төвийн бүс, Хангайн бүсийн салбарыг хамруулан ажлуудыг хийж гүйцэтгэн 220, 110, 35 кВ-ын ЦДАШ, дэд станцын хамгаалалтын зурвас зөрчилтэй ААН, айл өрхүүдэд учирч болох аюул эрсдэл, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн талаар сурталчилгаа хийх, хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэх, эрчим хүчний найдвартай ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлж **1280** албан мэдэгдэл, албан шаардлага айл өрх, аж ахуйн нэгжүүдэд тарааж, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх анхааруулга өгч ажилласан. (График №1-д үзүүлэв)

График №1



Аяны хүрээнд тоноглол түүний хамгаалалтын бүсэд Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн хэрэгжилтийг хангах иргэн, аж ахуй нэгжийг дагаж мөрдүүлэх хяналт шалгалт зөрчил арилгах ажлуудыг зохион байгуулж шинээр 70 хамгаалалтын зурвасын зөрчлийг илрүүлж, 47 зөрчлийг арилгуулж ЭХЯ, МХЕГ, НМХГ, ЦЕГ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгуудын МХГ зэрэг 10 гаруй байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ТЕХНОЛОГИЙН ЗӨРЧЛҮҮД:

Тус компанийн зүгээс цахилгааны аюул эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эдгээр айл өрх, аж ахуйн нэгжүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр сэрэмжлүүлэг мэдээлэл тогтмол явуулах, жил бүр хамгаалалтын зурвас чөлөөлөх албан шаардлага өгөх, эрсдэл өндөртөй цэгүүдэд анхааруулах самбарууд байршуулах зэрэг ажлуудыг шат дараалалтай зохион байгуулж байгаа хэдий ч зөрчлүүд буурахгүй харин ч нэмэгдсээр байна. 2022 онд 220/110 кВ-ын шугамын хамгаалалтын зурваст дараах технологийн зөрчлүүд бүртгэгдсэн.

Үүнд:

Улаанбаатар салбарт нийт 4 зөрчил бүртгэгдсэн.

1. **2022.03.04**-ний өдөр 110 кВ-ын 101, 102-р ЦДАШ-ын кабель гэмтэж 110/35/10 кВ-ын Налайх дэд станцаас 4,5 км-т унтралтын цэг буюу сигналгүй болсон. 2022.03.04-ны өдөр ДҮТ ТӨХХК болон тус компанийн бригадууд шугамыг засварт гарган тулгуур №77-78-н хооронд гэмтсэн шилэн кабелийг илрүүлэн (Ойролцоох цэргийн анги нэгтгэлүүд хээрийн сургуулилтын үеэр буудлага хийхдээ аянгын тросс бүхий шилэн кабелийг гэмтээсэн) сольж хэвийн схемд оруулсан. Цагдаад шалгагдаж байгаа. **(Гарсан нийт зардал 5,428,304.6 төгрөг)**

Зураг №1



2. **2022.08.01**-ний өдөр HOWO маркийн том оврын машины жолооч иргэн Д.Ариунболд нь 2022.08.01-ний өдөр 110 кВ-ын Дундгол цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №37-38-ын хооронд хүчдэлтэй утасны доогуур Цементийн СИЛОС ачиж тээвэрлэх явцдаа хүчдэлтэй утсанд ойртсоны улмаас Дундгол агаарын шугамын С фазад нөлөөллийн хүчдэлд орж газартай богино залгаа болж газардлагаар 3091А гүйдэл гүйснээр газардлагын хамгаалалт ажиллаж шугам тасарсан зөрчил гарсан. Цагдаад шалгагдаж байгаа. **(Гарсан нийт зардал 2,147,983 төгрөг)**

Зураг №2



3. **2022.10.21**-ний өдөр 220 кВ-ын ЦДАШ-ын хамгаалалтын зөрчил 8031 УАР улсын дугаартай FUSO маркийн том оврын крантай машины жолооч 220 кВ-ын 208-р ЦДАШ-н тулгуур №641-642-ын хооронд ачаа өргөх явцдаа зайн хэмжээнд орсоны улмаас үндсэн хамгаалалт ажиллаж шугам тасарсан зөрчил гарсан. Өмнө нь “Хамгаалалтын зурвас аян”-ны хүрээнд 2022.03.24-нд 957/2022 дугаартай мэдэгдэх хуудсыг зөрчил гаргасан Сонгино хайрхан дүүргийн 23-р хороо Хангайн 29-р гудамж 10А тоотын оршин суугч Ш.Батдоржид өгч байсан. **(Гарсан нийт зардал 305,753.21 төгрөг)**

Зураг №3



4. **2022.08.08**-ны өдөр 4013 УНЯ улсын дугаартай Hyundai маркийн 11 тн-ын краны жолооч иргэн М.Алтансүх нь 110 кВ-ын 107-р ЦДАШ-н тулгуур №13-14-ийн хооронд хүчдэлтэй утасны доор усны насос өргөх явцдаа нөлөөллийн хүчдэлд орж 107-р ЦДАШ үндсэн хамгаалалтаар тасарч АПВ амжилтгүй ажилласан. **(Гарсан нийт зардал 1,965,134 төгрөг)**

Зураг №4



Хангайн бүсийн салбарт нийт 2 зөрчил

1. **2022.08.15**-ны өдөр 110 кВ-ын Тэлмэн АШ-ын тулгуур №363-364-ийн хооронд замтай огтлолцсон хэсэгт овор ихтэй тээврийн хэрэгсэл шугамын дамжуулагч утсанд хүрч татагдсаны улмаас 17-20 митер орчим хэсэгт ган дамжуулагч шамарч, хөнгөн цагаан хэсгийн эрчлээс задарсан зөрчил гарсан. Цагдаад шалгагдаж байгаа. **(Гарсан нийт зардал 1,686,700 төгрөг)**

Зураг №5



2. **2022.10.21**-ний өдөр 110 кВ-ын Булган-А, Б ЦДАШ-ын тулгуур №209-210 хооронд трассын доор байрлалтай 220 В-ын модон тулгуурыг 65-56 БУА улсын дугаартай TOYOTA HAPPER маркийн автомашин мөргөж тухайн тулгуур унах үед шугамын утас тусгаарлагч понхноос муптарч харван 110 кВ-ын Булган-А ЦДАШ-ын 3-р фазын утсанд хүрч 110 кВ-ын Булган-Б АШ-ын 3-р фазын утсанд ойртож тулгуур №209-210 хооронд 3-р фазын утас 7-8 судал тасарсан зөрчил гарсан. Цагдаад шалгагдаж байгаа. (**Гарсан нийт зардал 1,030,000 төгрөг**)

Зураг №6



Говийн бүсийн салбарт нийт 1 зөрчил бүртгэгдсэн.

1. **2022.05.23**-ны өдөр 220 кВ-ын 215, 216 дугаар ЦДАШ-ын тулгуур №824-825-н хооронд автозамтай огтлолцсон хэсэгт том оврын ачааны автомашин өнгөрөх үед автомашины ачааны хэсэг шугамын утастай зайнд орсоноор 220 кВ-ын 215-р ЦДАШ бэлтгэл хамгаалалтаар тасарч АПВ-р амжилттай залгагдах үед 220/110/35 кВ-ын “Оюутолгой” дэд станцад 220 кВ-ын 218-р ЦДАШ газардлагын II шат мэдэрч 218-р ЦДАШ-ын таслуур тасарсан. 218-р ЦДАШ-н таслуур тасарснаар “Оюутолгой” дэд станцын 20 МВар-ын хоёр реактор системээс тусгаарлагдсан. Мөн 215-р ЦДАШ-н газардлагын богино залгааны үед 35 кВ-ын СВК-2 технологийн хамгаалалтаар тасарч Тавантолгой дэд станцад 220 кВ-ын шинийн хүчдэл 259 кВ болж өссөнөөр 215, 216-р ЦДАШ хүчдэл ихсэлтийн хамгаалалтаар тасарсан тасралт гарсан.

Зураг №7



Компанийн хэмжээнд 2022 онд цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст зөрчил 7 (Улаанбаатар салбарт 4, Хангайн бүсийн салбарт-2, Говийн бүсийн салбарт-1) бүртгэгдэж нийт **12,563,874.81** төгрөгийн хохирол гарсан.

Тасралтын мөрөөр зөрчил гаргасан эзэн холбогдогчийг тогтоож гэмтлийн акт бичигдэн нийт 8 удаагийн албан бичгүүдийг тухайн хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлэн зөрчлүүдийг шалгуулж хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авахаар ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2022-2023 ОНЫ ХУГАЦААНД ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АВТО ЗАМЫН ТРАСС ДАВХЦАХ, ОГТЛОЛЦСОН ЗӨРЧЛИЙН ТАЛААР:

Тус компанид Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс өнөөдрийг хүртэл 19 байгууллагын 56 байршилд авто замын тодруулга хийж ажилласан. Үүнээс 42 байршилд өндөр хүчдэлийн шугам сүлжээ байхгүй бөгөөд үлдсэн 14 байршилд өндөр хүчдэлийн шугамтай огтлолцож, зэрэгцэн байхаар төлөвлөгдөн зураг төсөл хийгдэн манай компаниар хянуулсан байна.

Эдгээр 14 байршлын 5 байршилд нь компанийн техникийн нөхцөл авсан ба 9 байршлын ажлын зураг зөвшилцөөгүй бөгөөд техникийн нөхцөл авах хүсэлтээ ирүүлээгүй болно.

Техникийн нөхцөл авсан 5 өндөр хүчдэлийн шугам.

1. 110 кВ-ын 109, 110-р ЦДАШ-д 1 удаа
2. 110 кВ-ын Үйлдвэр ЦДАШ-д 2 удаа
3. 110 кВ-ын Үйлдвэр, 35 кВ-ын Холбоо А,Б 1 удаа
4. 110 кВ-ын 107, 108-р ЦДАШ-д 1 удаа тус тус олгосон.

ЦДАШ-ын хамгаалалтын зурваст огтлолцох, зэрэгцэн явах авто замын зөвшилцсөн зургийн ажлууд:

Хүснэгт №01

№	Гүйцэтгэж буй ажил	Хэдэн байршилд	Байгууллагын нэр	Утас
1	Гүүр, Автозам	1	ГБЭТ ХХК	99196214
2	Автозам	2	Жи Ар Си ХХК	91916394
3	Автозам	3	Эн Би Си Си ХХК	99551395
4	Автозам	3	Ростов ХХК	88119308
5	Автозам	6	Засмал зам ХХК	77550070
6	Автозам	13	Монголиан нэйшнл хайвэй ХХК	99078483
7	Автозам	20	Гео зураглал ХХК	313693
8	Автозам	1	Ти Ай Би ХХК	99112869
9	Автозам	1	Гео Урбан Консалтинг ХХК	88095961
10	Автозам	1	Анандын зам ХХК	70130001

ЦДАШ-ын хамгаалалтын зурваст бүртгэгдсэн зөрчилтэй авто замын ажил

Хүснэгт №02

№	Шугамын нэр	Тулгуур	Гүйцэтгэж буй ажил	Байгууллагын нэр	Утас	Тайлбар
1	107, 108 Улаанхуаран салбар	Салбар тулгуур № 1-2	Автозам	Неон ХХК гэгээ	88114050	Зөрчилтэй
2	107, 108	тулгуур №12-13	Гүүр	Туулын гүүр далай ХХК	80081085	Зөрчилтэй
3	120	тулгуур №22-23	Автозам	Анандын зам ХХК	99075231	Зөрчилтэй
4	Яармаг А,Б Буянт Ухаа салбар	тулгуур №7-8	Автозам	Тэмүүн холдинг ХХК	91920056	Зөрчилтэй

“Эрчим хүчний тухай хууль”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн холбогдох заалт, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст 2022-2023 онуудад Нийслэлийн хэмжээнд шинээр төлөвлөгдөж буй автозам, гүүрийн байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа манай компанитай зөвшилцөх, хамгаалалтын зурваст шугамын трассыг давхцуулахгүй байх талаар эдгээр саналыг БХБЯ-ны ажлын хэсэгт хүргүүлсэн.

БХБЯ-НЫ АЖЛЫН ХЭСЭГТ АЖИЛЛАСАН ТАЛААР:

Барилга хот байгуулалтын яамны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 246 дугаартай тушаалаар байгуулагдсан “Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын талаар авах зарим арга хэмжээний хүрээнд эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох, мэдээллийг Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, хамгаалалтын зурваст газар дахин олгохгүй байх, олгогдсон газрыг чөлөөлүүлэх” ажлын хэсэгт тус компаниас орж ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гарган батлуулан ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлууд хийгдсэн бөгөөд бусад ажлуудыг 2023 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

1. Нийслэлийн Хот байгуулалтын хөгжлийн газраас ирсэн 06/296 тоот албан бичгийн дагуу ХАБЭА-н инженер, шугамын инженер нар НХБХГ-ын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран 220, 110, 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 33 дэд станцын шугам сүлжээний хамгаалалтын зурвасын мэдээллийн санд тулгалт хийсэн. Уг тулгалтаар 220 кВ-ын 203, 204, 209, 210, 110 кВ-ын 101,102 агаарын шугамын мэдээлэл дутуу, 220 кВ-ын 211,212, 110 кВ-ын 119, 121, 122, 129,130, 137,138, 127, 128, 123,124 агаарын шугамын мэдээлэл ороогүй байсныг шинэчилж оруулсан.
2. Нийслэлийн Засаг даргад 2022.10.17-нд 02/1451 дугаартай албан бичгээр өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст зайлшгүй шаардлагатай айл өрх, аж ахуйн нэгжүүдэд газар олгосон зөвшөөрлийг цуцлах, олгосон газрыг өргөтгөн хашаа, барилга барьсан зөрчлийг арилгуулах чиглэлээр мэдээллийг шинэчлэн Баянгол, Сонгино хайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд нийт 127 зөрчлийг 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж талаар хөөцөлдөн ажиллаж байна.

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН АСУУДЛААР:

Эрчим хүчний тухай хуулийн 14.4-т “Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна” гэж заасан байдаг бөгөөд Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө”, мөн уг хуулийн 7.2-т “Газрын төлбөрийн хэмжээ, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх, зарцуулах журмыг хуулиар тогтооно” гэж тус тус заасан хууль эрх зүйн зохицуулалтай байна.

Мөн Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-н 4.1.1, 4.1.4-т зааснаар дамжуулах сүлжээ нь хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалалтын зурвасын байршлын зураглалыг хийх, хамгаалалтын зурвасыг тогтоолгох тухай шийдвэрийг аймаг, нийслэл сум дүүргийн Засаг даргаар гаргуулах, хангах ажлыг гүйцэтгэх үүргийг эзэмшигч байгууллага хүлээдэг. Монгол улсын өмнөд бүсэд өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор Чойр-Сайншанд-Замын үүд, Сайншанд-Цагаан суварга, Мандалговь-Арвайхээр дэд станцуудад холбосон ЦДАШ, дэд станцын өргөтгөлийн ажлууд, нийслэл хотын дагуул хот болох Төв аймгийн нутагт шинэ дэд станцууд болон тэдгээрийг холбосон 2000 гаруй км цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинээр барих барилга байгууламжийн хэтийн стратеги төлөвлөлт хийгдсэн болно.

Тус компанийн эзэмшлийн Улаанбаатар хот болон орон нутгийн хэмжээнд одоо ашиглаж байгаа /5508,002 км/ болон шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөж буй /2000 км/ ЦДАШ, 92ш ИХБ, дэд станцуудын газрын төлбөрт төлөх төлбөрийн хэмжээг өнөөгийн мөрдөж буй хуулиар болон шинэчилсэн хуулийн төслийн төсөвт өртгөөр ойролцоогоор тооцоолон гаргахад тус компанийн дэд станц, ЦДАШ-ын суурь үнэлгээг хот, тосгон бусад суурин газрын аль тойрог, зэрэглэлд хамаарч байгаагаас шалтгаалан тооцоолон гаргахад **ИХБ, дэд станцад 112.7 сая төг, ЦДАШ-д 56,3 сая төг**, БХБЯ-наас шинэчлэн боловсруулсан “Газрын төлбөрийн тухай” хуулийн газрын төлбөрийг 1 км тутамд 75000 төгрөгөөр ИХБ, дэд станц, ЦДАШ-ын хамгаалалтын зурвас газрын хэмжээг талбайгаар тооцоход **ИХБ, дэд станцад 120 сая төг, ЦДАШ-д 1,2 тэрбум** төгрөгийн төлбөрийг төлөхөөр гарч байна.

Энэ тооцоогоор 220/110 кВ-ын 92ш дэд станцын ашиглалтын насжилтыг 35 жилээр тооцвол **4,2 тэрбум**, 7508,002 км 220/110 кВ-ын ЦДАШ-ын насжилт 60 жил гэж тооцвол **72 тэрбум** төгрөгийн газрын төлбөр гарч байна.

Иймд тооцооллоор газрын төлбөр 76,2 тэрбум төгрөгийг “Газрын төлбөрийн тухай” хуулийн төсөлд тусгаснаар 90 хувь хүртэл хөнгөлөх боломжтой боловч манай компанийн элэгдлийн зардлыг ЭХЗХ-с 9,6 тэрбум төгрөгөөр баталж байгаа тул дээрх төлбөрийг төлөх боломжгүй учраас ЭХЯ-нд 2022.02.11-нд 01/201 дугаартай албан бичгээр хандан БХБЯ-наас шинэчлэн боловсруулсан “Газрын төлбөрийн тухай” хуулийн төсөлд ИХБ, дэд станц, ЦДАШ-ын зурвас газрын эзэмших эрхийг баталгаажуулах, газрын төлбөрөөс 100 хувь чөлөөлүүлэх хүсэлтээ хүргүүлэн ажиллаж байна.

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС